

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023-2028



АДБОУБ



**АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА**

ТАНИЛЦУУЛГА

Энэ нь Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага (АДБОУБ)-ын стратеги төлөвлөгөө юм. Тус төлөвлөгөө нь 2023-2028 он хүртэлх байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, байгууллагын тэргүүлэх чиглэл, стратегийн зорилтуудыг тусгасан.

АДБОУБ бол “харилцан туршлага солилцох нь бүгдэд ашиг тустай” урианы дор төрийн салбарын олон аудитын байгууллагуудыг нэгтгэж, дэмжин ажилладаг дэлхийн байгууллага юм.

АДБОУБ болон түүний гишүүд илүү давшингүй, харилцан уялдаатай бөгөөд төвөгтэй орчинд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэд засгийн газар, ард иргэддээ үнэ цэнэ, ашиг тусыг хүргэхийн тулд мэргэжлийн, хараат бус, хүртээмжтэй, уян хатан байх шаардлагатай.

АДБОУБ нь дараах таван үндсэн чиглэлийг анхаарч, үйл ажиллагаандаа тусгана.

1. АДБ-ын хараат бус байдлыг хамгаалах, дэмжих;
2. Тогтвортой хөгжил – 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах;
3. АДБ-ын хөрвөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
4. АДБОУБ-ын нийгэмлэгийн тэгш байдал, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, дэмжих;
5. Стратегийн түншлэлийн харилцааг сайжруулах.

АДБОУБ дараах чиглэлд анхаарсан үндсэн дөрвөн стратегийн зорилттой холбоотой үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах болно.

1. төрийн салбарын аудитын мэргэжлийн стандарт;
2. АДБ-ын чадавхыг хөгжүүлэх;
3. АДБ-ын мэдлэгийг хуваалцах, үйлч илгээ үзүүлэх;
4. АДБОУБ-ын сайн засаглал.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ АДБОУБ нь үйл ажиллагааныхаа арвилан хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, санхүү, хүний нөөцийг оновчтой удирдах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах шилдэг туршлагыг үргэлжлүүлэн судалж, хэрэгжүүлэх болно.

Энэхүү стратегийг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй төлөвлөгөөг АДБОУБ-ын www.intosai.org цахим хуудаснаас авах боломжтой. АДБОУБ нь тэргүүлэх чиглэл, стратегийн зорилгодоо хүрэхийн тулд аливаа үйл явцтай уялдуулан эдгээр төлөвлөгөөг жил бүр хянаж, явцад нь хяналт шинжилгээ хийж, шаардлагатай бол шинэчилж байх болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

АДБОУБ-ын эрхэм зорилго нь төрийн салбарын хариуцлагатай байдалд үр өгөөжтэйгөөр хувь нэмрээ оруулах, төрийн ил тод байдал, сайн засаглалыг дэмжих, бүх нийтийн ашиг тусын тулд засгийн газрын хөтөлбөрүүдийн арвилан хэмнэлт, үр өгөөж, үр ашгийг дээшлүүлэхэд гишүүддээ дэмжлэг үзүүлэх явдал юм.

АЛСЫН ХАРАА

АДБОУБ нь гишүүддээ төрийн салбарын хариуцлагыг дээшлүүлэх замаар засаглалыг бэхжүүлэх, улмаар ард иргэдийн амьдралыг сайжруулах хүчин чармайлтаа бүрэн дүүрэн ашиглах боломжийг олгодог олон улсын тэргүүлэгч байгууллага болон хөгжиж байна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

АДБОУБ нь хариуцлагатай байдал, мэргэжлийн ур чадвар, хамтын ажиллагаа, тэгш байдлын үнэт зүйлсийг баримталдаг.

“Аудитын дээд байгууллага (АДБ) гэж юу вэ?”

АДБ нь төрийн аудитын хамгийн дээд чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн болон үндэстэн дамнасан төрийн дээд байгууллага юм. АДБ-ууд төрийн аудитын чиг үүргээ хараат бус, бодитойгоор хэрэгжүүлдэг. АДБ-ын аудит болон эрх зүйн чиг үүрэг нь тэдний бүрэн эрх, үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчноос хамааран харилцан адилгүй байдаг.

БИД ХЭН БЭ

АДБОУБ нь төрийн болон үндэстэн дамнасан аудитын дээд байгууллага (АДБ)-ууд болон олон улсын мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн хараат бус, бие даасан, мэргэжлийн, улс төрийн бус байгууллага юм. 2022 оны байдлаар бид 196 жинхэнэ гишүүн, 5 дэд гишүүн, 2 харьяа гишүүнтэй байна.

АДБОУБ нь Нэгдсэн үндэсний байгууллага болон түүний төрөлжсөн агентлагууд, олон улсын байгууллагууд, хандивлагчдын нийгэмлэг, авлигатай тэмцэх дэлхийн байгууллагууд зэрэг холбогдох байгууллагуудтай бүтээлч түншлэлийн харилцаатай байдаг.

БИД ЮУ ХИЙДЭГ ВЭ

АДБОУБ-ын үйл ажиллагаа нь төрийн аудитын мэргэжлийн мэдэгдлүүд (зарчим, стандарт, заавар) боловсруулах, түгээх, хадгалах, түүнчлэн АДБ-ын чадавхыг хөгжүүлэх, мэдлэг хуваалцахад чиглэдэг.

АДБОУБ нь АДБ-уудад харилцан дэмжлэгээр хангадаг; шинэ санаа, мэдлэг, туршлага солилцоход дэмжлэг үзүүлдэг; олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд АДБ-ын хүлээн зөвшөөрөгдсөн дэлхий нийтийн дуу хоолой болж ажилладаг; төрийн салбарын аудитын стандартыг тогтоодог; үндэсний сайн засаглалыг дэмждэг; АДБ-ын чадавхыг хөгжүүлэх, хамтын ажиллагаа, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.

БИД ХЭРХЭН ҮР ДҮНД ХҮРЧ, ҮР ДҮНГЭЭ ХЭРХЭН ХЭМЖДЭГ ВЭ

АДБОУБ нь харилцан дэмжлэг үзүүлэх, мэдлэг солилцох, төрийн салбарын аудитын стандарт, удирдамжийг боловсруулах, холбогдох нөөцийг хөгжүүлэх, хуваалцах, АДБ-ын чадавхыг хөгжүүлэх, АДБОУБ-ын эрхэм зорилгыг дэмждэг стратегийн түншүүдтэй дэлхий дахины хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар зорилтоо хэрэгжүүлдэг. АДБОУБ-ын зорилго, зорилтод хүрэх стратеги, мөн түүнчлэн гүйцэтгэлийн хэмжүүрийг тусад нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр жил бүр хянаж, шинжилгээ, үнэлгээ хийдэг. Мөн АДБОУБ тэргүүлэх чиглэл, зорилгодоо хүрэхэд гарсан ахиц дэвшлийн талаар гурван жил тутамд олон нийтэд нээлттэй мэдээлдэг.

АДБОУБ гишүүд, хандивлагчдын оруулсан санхүүгийн эх үүсвэр болон гишүүд, түншүүдийнхээ хүний ба бусад нөөцөөр оруулсан мөнгөн бус хувь нэмрээр үйл ажиллагаагаа явуулдаг.



АДБОУБ-ын ЭРХЭМ ЗОРИЛГО



Төрийн салбарын хариуцлагатай байдалд үр өгөөжтэйгөөр хувь нэмрээ оруулах, сайн засаглалыг дэмжих, засгийн газрын хөтөлбөрүүдийн арвилан хэмнэлт, үр өгөөж, үр ашгийг дээшлүүлэхэд АДБ-уудад дэмжлэг үзүүлэх

АДБ-д үзүүлэх ашиг тус



АДБ-ын өндөр чанартай үйл ажиллагаа

Хараат бус, учир холбогдолтой, нотлох баримтад үндэслэсэн аудит ба бусад бүтээгдэхүүн



Харилцан дэмжлэг

Мэдлэг хуваалцах, аудитын стандарт, заавар боловсруулах үр өгөөжтэй хэлэлцүүлэг



Чадавх ба хөрвөх чадвар

АДБ-ууд өөрчлөлтийг хүлээн авах болон онцгой нөхцөл байдалд хариу илүү сайн үйлдэл үзүүлэх чадвартай



АДБ-уудын хараат бус байдал

Гүйцэтгэх засаглалын байгууллагуудын нөлөөллөөс хамгаалсан хамгаалалт болон хууль, эрх зүйн бүрэн эрхтэй АДБ-ууд



Тэгш байдал ба хүртээмжтэй байдал

АДБОУБ-ын хүрээнд тэгш боломж, АДБ-уудын хүрээнд хүртээмжтэй бодлого, үйл ажиллагаа, аудит



Дэлхий нийтийн дуу хоолой

төрийн аудитын асуудлаар АДБ-ыг төлөөлж буй дэлхий нийтийн дуу хоолой, стратегийн түншүүдтэй өрнүүлж буй яриа хэлэлцээ



Тогтвортой Хөгжлийн зорилт

НҮБ-ын Тогтвортой хөгжил - 2030 хөтөлбөрт хүрэхэд дэмжлэг үзүүлэх нэгдсэн хүчин чармайлт



Сайн засаглал

АДБ-ын ашиг тусын тулд АДБОУБ-н үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор АДБОУБ-н үйл ажиллагаа, нөөцийг үр дүнтэй удирдах

Нийгэмд үзүүлэх ашиг тус

- Засгийн газрын үйл ажиллагаа болон АДБ-ын чиг үүрэгт олон нийтийн итгэх итгэл, үнэмшлийг нэмэгдүүлэх
- Төрийн үйлчилгээг үзүүлэх мөнгөний үнэ цэнэ
- Тэгш байдал, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн засгийн газрын хөтөлбөр, үйлчилгээ
- Төрийн болон засгийн газрын байгууллагуудын илт тод байдал, хариуцлага, шударга ёс сайжрах
- Төрийн салбар дах залилан, авлига буурах
- Эрүүл эдийн засаг, илүү санхүүгийн тогтвортой байдал
- Хариуцлагын талаарх мэдээллийг түргэн шуурхай олж авах боломжийг иргэдэд олгох
- Төрийн хөрөнгө, байгаль орчны хөрөнгүүдийг илүү сайн удирдах



ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: АДБ-ын хараат бус байдлыг дэмжих, дэмжлэг үзүүлэх

АДБОУБ нь бүх аудитын дээд байгууллагын хараат бус байдлыг дэмжин ажилладаг. АДБОУБ нь өөрийн ажлын хэсгүүд болон бүс нутгийн байгууллагуудаараа дамжуулан гишүүн АДБ-ууддаа учирч буй аюул заналыг бууруулах, хараат бус байдлыг нь бэхжүүлэх хүчин чармайлтыг сурталчлан дэмжиж, улмаар төрийн салбарын аудитын чиг үүргээ хамгийн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Хараат бус байдал нь АДБ-ын хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, улмаар хариуцлага тооцох, төрийн байгууллагын ил тод байдлыг дэмжих, үр нөлөөг нэмэгдүүлэхэд үр дүнтэй хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой. АДБ-ууд аудит хийдэг байгууллагуудаасаа хараат бус байж, гаднын нөлөөллөөс хамгаалагдсан байх нь чухал. Үүнд хууль эрх зүйн бүрэн эрх, эрх мэдэлтэй байх, гүйцэтгэх засаглалын байгууллагуудын санхүүгийн болон захиргааны хөндлөнгийн оролцооноос хамгаалах, аудитын үр дүнг тайлагнах ил тод байдал зэрэг хүчин зүйлүүд орно. Дэлхийн Банк болон АДБОУБ-н Хөгжлийн Санаачилга нь АДБ-ын хараат бус байдлыг хангахад тулгамдаж буй шинээр бий болж буй сорилтуудыг тодорхойлсон.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: Тогтвортой хөгжил – 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах

АДБОУБ нь Тогтвортой хөгжил - 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. АДБОУБ өөрийн ажлын хэсгүүд болон бүс нутгийн байгууллагуудаараа дамжуулан НҮБ-ын Тогтвортой хөгжил - 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндэсний санаачилгын өндөр чанартай, холбогдох аудитыг сурталчлах, дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэх гишүүн АДБ-уудын хүчин чармайлтыг дэмждэг.

АДБ-ууд 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тусын улс орнуудын үндэсний хөгжлийн төлөвлөгөөгөөр дамжуулан аудит хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. АДБ-ууд аудитаар дамжуулан хэрэгжилтийн үйл явцыг ил тод тайлагнаж, юуг сайжруулах боломжтой талаар ойлголтыг өгдөг. АДБОУБ нь гишүүн АДБ-уудаа улс орныхоо тогтвортой хөгжлийн хүчин чармайлт, АДБ-ын хараат бус бүрэн эрхийн хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудын аудитад хувь нэмрээ оруулахыг дэмждэг. Үүний зэрэгцээ АДБОУБ нь өөрийн дотоод, гадаад үйл ажиллагаа, чиг үүргээ тогтвортой тогтвортой хэрэгжүүлэхийг зорьдог.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: АДБ-ын хөрвөх чадварыг дэмжих

АДБОУБ нь АДБ-ын хөрвөх чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. АДБОУБ нь ажлын хэсгүүд болон бүс нутгийн байгууллагуудаараа дамжуулан гишүүн АДБ-уудынхаа өөрчлөлтөд дасан зохицох, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, боломжийг ашиглах, эрсдэлийн удирдлагын арга барилыг дээшлүүлэх, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах чадавх, ур чадварыг хөгжүүлэх хүчин чармайлтыг дэмждэг.

Нийгмийн бусад бүлгийн нэгэн адил АДБ-ын үйл ажиллагаанд улс төрийн тогтворгүй байдал, эрүүл мэндийн онцгой байдал, эдийн засаг, төсвийн хямрал, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, дэлхийн цаг уурын хямрал зэрэг тодорхойгүй эсвэл урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал нөлөөлдөг. Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн хурдацтай өөрчлөлтийг засгийн газар, хувь хүмүүс ашиглах боломжтой болсон байна. Эдгээр хурдацтай хөгжиж буй нөхцөл байдал нь АДБ-уудад засгийн газар болон иргэдэд үйлчлэх боломжийг олгохын зэрэгцээ сорилтуудыг бий болгож байна.



ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4: Тэгш байдал ба хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, дэмжих

АДБОУБ нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд, гишүүн АДБ-ууд өөрсдийгөө удирдах арга барил, мөн эдгээр сэдвээр хийсэн аудитын талаарх АДБ-уудын мэдлэгийг хуваалцах замаар тэгш байдал, хүртээмжтэй байдлыг дээшлүүлж, дэмждэг. АДБОУБ нь ажлын хэсгүүд болон бүс нутгийн байгууллагуудаараа дамжуулан гишүүдийнхээ өвөрмөц онцлогийг ойлгохыг эрмэлздэг бөгөөд АДБОУБ-н санаачилгуудад оролцох, хувь нэмэр оруулах, үр шимийг хүртэх, АДБ-ын ажилтнуудад тэгш боломжийг олгох мөн тэгш байдал, хүртээмжтэй байдлыг шийдвэрлэх засгийн газрын хүчин чармайлтын үр дүнтэй аудитаар хангахад гишүүн АДБ-уудын хүчин чармайлтыг дэмждэг.

АДБОУБ нь АДБ-ын үйл ажиллагаа явуулж буй өөр өөр нөхцөл байдлыг бүрэн хүлээн зөвшөөрч, хариу үйлдэл үзүүлсэн болон олон талыг хамарсан бодлого, үйл ажиллагаа, аудитыг хэрэгжүүлэхэд нь АДБ-ыг дэмждэг.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5: Стратегийн түншлэлийг сайжруулах

АДБОУБ нь зорилгодоо хүрэхийн тулд стратегийн түншлэлийг сайжруулдаг. АДБОУБ өөрийн ажлын хэсгүүд болон бүс нутгийн байгууллагуудаараа дамжуулан бусад олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлдэг бөгөөд энэ нь АДБОУБ болон түүний гишүүн АДБ-уудад харилцан ашиг тустай байдаг. АДБ-ын мэргэжлийн сүлжээний хувьд АДБОУБ нь олон улсын хамтын нийгэмлэг дэх төрийн аудитын дэлхий нийтийн дуу хоолой юм. АДБОУБ-н гишүүд болон түншүүд төрийн аудитын ач холбогдол, үр нөлөөний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, АДБ-ын нийгэмд үзүүлэх үнэ цэнийг сурталчлах зорилгоор холбогдох талуудтай идэвхтэй хамтран ажиллах сонирхлыг хүлээн зөвшөөрдөг.

АДБОУБ нь стратегийн зорилгодоо хүрэхийн тулд Нэгдсэн үндэсний байгууллага болон түүний салбар байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, төрийн бүс байгууллагууд, хандивлагчдын нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагуудтай стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлж ирсэн түүхтэй. Цаашлаад АДБОУБ засгийн газрын хариуцлага, ил тод байдлын талаарх дэлхийн болон бүс нутгийн түвшний яриа хэлэлцээнд идэвхтэй хувь нэмэр



Доор жагсаасан дөрвөн стратегийн зорилго болон холбогдох стратегийн зорилтууд нь АДБОУБ болон түүний гишүүн АДБ-уудыг төрийн салбарын үр дүнтэй аудит, төрийн хариуцлага, ил тод байдлыг хангахад хувь нэмрээ оруулахад чиглүүлдэг. 1-3-р зорилтууд нь мэргэжлийн стандартыг сайжруулах, чадавхыг хөгжүүлэх, гишүүд болон тэдгээрийн харилцагч талуудын дунд төрийн салбар дахь мэдлэг хуваалцах замаар АДБОУБ-н гишүүдийг дэмжихэд чиглэдэг. Зорилт 4 нь АДБОУБ-н үйл ажиллагааг эдгээр зорилтуудтай уялдуулах зорилготой юм.

АДБОУБ-н бүх байгууллагууд төлөвлөсөн үр дүндээ хүрэх зорилгоор хамтын зорилго, байгууллагын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй хамтран ажиллах чиг үүрэг хамтдаа хариуцдаг.



ЗОРИЛГО 1: АДБ-уудын мэргэжлийн стандартуудыг боловсруулах, хадгалах, дэмжих

АДБОУБ нь олон нийтийн ашиг сонирхлын үүднээс төрийн аудитын чанар, ур чадвар, найдвартай байдал, хараат бус байдал, учир холбогдолтой байдлыг дэмжих олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн зарчим, стандарт, удирдамжаар хангах, хадгалах, дэмжих замаар АДБ-ын үр дүнтэй үйл ажиллагааг дэмжих болно.

Стратегийн зорилтууд

1.1 АДБОУБ-н мэргэжлийн мэдэгдлийн хүрээг (ИММХ) зарчимд суурилсан байдлаар үргэлжлүүлэн хөгжүүлж, заавар болон бусад туслах материалын шинэлэг, уян хатан байдлыг хангах.

1.2 ИММХ-ний тууштай, мэргэжлийн ур чадвар, чанар, учир холбогдолтой байдлыг баталгаажуулж, аудитын мэргэжил гарч буй хөгжил шинэчлэл, хэрэглэгчийн санал хүсэлтийн дагуу ИММХ-ний мэргэжлийн агуулгыг тогтмол шинэчилж байх.

1.3 ИММХ-ний материалыг ойлгомжтой боловсруулан танилцуулж, технологийг ашиглан хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар ашиглах боломжоор хангах.

1.4 ИММХ-ний хэрэглээ, учир холбогдолтой байдал дээр санал авах, сайжруулах боломжийг тодорхойлохын тулд АДБ-ууд ИММХ-ний хэрэгжилтийг дэмжих, түүнд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх.



ЗОРИЛГО 2: АДБ-уудыг чадавхаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

АДБОУБ нь АДБ-уудын мэргэжлийн чадавх, ур чадварыг хөгжүүлэх замаар нийгэмд авчрах үнэ цэнэ, ашиг тусыг нэмэгдүүлэх чадамжийг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. “Хэнийг ч хойноо орхихгүй” гэсэн хүсэл эрмэлзэлтэй 2-р зорилго нь АДБОУБ-н бүх гишүүдийг дэмжих үүднээс АДБ-ын чадавхыг тогтвортой хөгжүүлэх талаар АДБОУБ шийдвэр гаргахад мэдээллээр хангадаг.

Стратегийн зорилтууд

2.1 АДБ-ын чадавхыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг дэмжих АДБОУБ-н хүрээний санаачилга гаргах, дэмжих, хэрэгжүүлэх.

2.2 АДБ-ын мэргэжлийн чадвар, аудиторын мэргэжлийн ур чадвар болон АДБ-ын ирээдүйн сорилтуудыг тогтвортой даван туулах чадавхыг дэмжих үүднээс АДБОУБ-н дотоод болон гадаад стратегийн түншлэлийг бий болгох.

2.3 Чадавхыг хөгжүүлэх мэдлэг, туршлагыг хуваалцаж, түүнийг хөгжүүлэхтэй холбоотой сорилт, боломжуудын талаар харилцан ярилцах.



ЗОРИЛГО 3: Мэдлэг хуваалцах замаар АДБ-ын хамтын ажиллагааг дэмжих

АДБОУБ нь мэдлэгийг хөгжүүлэх, мэдлэг хуваалцах, мэдлэгийн үйлчилгээгээр дамжуулан АДБ-ын хамтын ажиллагаа, байнгын хөгжлийг дэмжих болно.

Стратегийн зорилтууд

3.1 Төрийн аудитын тодорхой сэдвийн хүрээнд мэдлэгийг бий болгож, хөгжүүлж, АДБОУБ-н мэргэжлийн мэдэгдлийн хүрээ болон бусад бүтээгдэхүүний агуулгыг боловсруулах, хуваалцах зорилгоор АДБОУБ-н бусад байгууллагуудтай хамтран ажиллах.

3.2 Ажлын хэсэг болон тусгай бүлгээр дамжуулан өргөн хүрээний мэдлэг, туршлага солилцох, мөн АДБОУБ-н гишүүдийн хооронд цахим арга хандлагад ач холбогдол өгөх замаар үр дүнтэй харилцаа холбоог бий болгох.

3.3 Шилдэг туршлагын судалгаа, семинар, вебинар, сонирхсон болон анхаарал татсан асуудлаар судалгаа хийх, дэлхийн мэдлэгийн төвүүдийг байгуулах зэрэг мэдлэг хуваалцах үйл ажиллагаануудаар дамжуулан АДБ-ыг тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлэх.



ЗОРИЛГО 4: АДБОУБ-н үнэ цэнийг нэмэгдүүлэх

INTOSAI нь эдийн засгийн хэмнэлттэй, үр ашигтай, үр дүнтэй, хамааралтай, шинэлэг ажлын туршлага, цаг тухайд нь шийдвэр гаргах, түргэн шуурхай засаглалын туршлагыг сурталчлах болно.

Стратегийн зорилтууд

4.1 АДБОУБ-н стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, түүний дотор АДБОУБ-н гүйцэтгэлийн удирдлагад хяналт тавих.

4.2 Стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхийн тулд АДБОУБ-н нөөцийг удирдаж, хяналт тавих.

4.3 АДБОУБ-Хандивлагч байгууллагуудын хамтын ажиллагааны хүчин чармайлтыг тогтвортой байлгаж, цаашид хөгжүүлэх.

4.4 АДБОУБ-н зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаа, харилцаа холбоо, зохицуулалт, шийдвэр гаргах үйл явц, олон нийтэд чиглэсэн АДБОУБ-н санаачилгууд нь АДБ болон АДБОУБ-д ашиг тустайгаар хэрэгжиж байгааг баталгаажуулах.

4.5 АДБОУБ-н стратегийн зорилтууд болон бүс нутгийн байгууллагуудын хүрээнд АДБОУБ-н хүчин чармайлтыг уялдуулахын зэрэгцээ АДБ-уудын хэрэгцээ шаардлагад хариу өгөхөд АДБОУБ-г дэмжих.

4.6 АДБОУБ-н үйл ажиллагаанд тэгш байдал, хүртээмжтэй байдлыг дэмжих.



ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ЧИГ ҮҮРЭГ

Аудитын дээд байгууллагуудын олон улсын их хурал (ИНКОСАИ)

АДБОУБ-н Их хурал нь АДБОУБ-н дээд байгууллага юм. Гурван жил тутамд хуралддаг бөгөөд АДБОУБ-н бүх гишүүдээс бүрддэг. Дүрэм, Стратегийн төлөвлөгөө эсвэл гурван жилийн төсөвт оруулах нэмэлт өөрчлөлт зэрэг АДБОУБ-н үндсэн асуудлуудын хамгийн чухал шийдвэрийг ИНКОСАИ дээр гаргадаг. Цаашлаад Их хурал нь АДБОУБ-н бүх гишүүдэд туршлага солилцох, цаг үеийн асуудлаар ярилцах, дэлхийн хэмжээнд төрийн хариуцлагыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг хуваалцах боломжийг олгодог.

Удирдлагын зөвлөл

Удирдлагын зөвлөл Их хурлын үеэр болон хурлын хооронд стратегийн манлайлал, удирдлага, тасралтгүй байдлыг хангах зорилгоор жил бүр хуралддаг. Удирдлагын зөвлөл нь Зорилтуудын хороод, Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар, АДБОУБ-н хөгжлийн санаачилга, АДБОУБ-н төрийн аудитын сэтгүүл, бүс нутгийн байгууллагууд зэрэг АДБОУБ-н байгууллагуудын жил бүрийн стратегийн тойм болон бусад тайлангуудыг хүлээн авч, шаардлагатай тохиолдолд шийдвэрлэдэг.

Удирдлагын зөвлөл нь АДБОУБ-н байгууллага болон бүс нутгийн байгууллагуудыг төлөөлсөн 22 гишүүнтэй. Удирдах зөвлөлийн дарга нь сүүлийн их хурлыг зохион байгуулсан АДБ-ын дарга юм.

Ерөнхий нарийн бичгийн дарга нарын алба

Вена хотод Австрийн аудитын шүүхийн дэргэд байрладаг Ерөнхий нарийн бичгийн дарга нарын алба нь АДБОУБ-д стратегийн болон төв захиргааны дэмжлэг үзүүлдэг. Австрийн

аудитын шүүхийн ерөнхийлөгч нь албан тушаалын дагуу АДБОУБ-н Ерөнхий нарийн бичгийн даргаар ажилладаг.

Байгууллагын байнгын ажиллагаатай байгууллага болохын хувьд Ерөнхий нарийн бичгийн дарга нарын алба нь тасралтгүй байдал, уялдаа холбоог эрхэмлэдэг. Ерөнхий нарийн бичгийн дарга нарын алба АДБОУБ-н санхүүг удирдан чиглүүлж, гарын авлага, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж, гишүүдийн мэдээллийн санг хөтөлж, байнга шинэчилж, АДБОУБ-н www.intosai.org цахим хуудсыг ажиллуулдаг. Ерөнхий нарийн бичгийн дарга нарын алба нь АДБОУБ-н гишүүдийн хоорондын харилцаа холбоонд дэмжлэг үзүүлж, Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ) болон бусад гаднын харилцагч талуудтай харилцах гүүр болж ажилладаг.

Зорилтын хороод

АДБОУБ-н дөрвөн зорилтын хороо нь мэргэжлийн стандарт, чадавхыг хөгжүүлэх, мэдлэг хуваалцах, засаглал зэрэгт тус тус анхаарал хандуулдаг. Зорилтын хороод нь тус тусын зорилгынхоо хүрээнд АДБОУБ-н хүчин чармайлтыг удирдан чиглүүлж, улмаар Удирдах зөвлөлд АДБОУБ-н зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Эдгээр хороодын үйл ажиллагаанд ойролцоогоор 25 туслах байгууллага хувь нэмрээ оруулдаг.

АДБОУБ-н мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор байгуулагдсан хороод, дэд хороод, ажлын хэсэг, тусгай бүлэг, туршлагын нийгэмлэгүүд нь мэргэжлийн ажлуудыг гүйцэтгэдэг. Энэ нь мэргэжлийн стандарт, аудитын удирдамж болон бусад практик лавлах материалыг боловсруулах, сайн туршлагыг төрөл бүрийн хэлбэрээр хуваалцах, мэргэжлийн яриа хэлэлцээг зохион байгуулах, оролцоо, инновац, хөгжлийг дэмжих үүднээс санал, туршлага солилцох замаар зохион байгуулагддаг.

Мэргэжлийн Стандартын Хороо (МСХ) нь төрийн аудитын учир холбогдолтой, ойлгомжтой олон улсын стандарт, зааварчилгаагаар АДБ-уудыг

хангах ажлыг удирдан чиглүүлдэг.

Чадавхыг бэхжүүлэх хороо (ЧБХ) нь АДБ-ын чадавхыг хөгжүүлэх АДБОУБ-н зөвлөгч, чиглүүлэгч юм.

Мэдлэг Хуваалцах, Мэдлэгийн Үйлчилгээний Хороо (МХМҮХ) нь мэдлэгийг хөгжүүлэх, хуваалцах, мэдлэгийн үйлчилгээгээр дамжуулан АДБ-ын хамтын ажиллагаа, байнгын хөгжлийг дэмждэг.

Бодлого, санхүү, захиргааны хороо (БСЗХ) нь гишүүн АДБ-ууд болон олон улсын байгууллагын хувьд АДБОУБ-н үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зорьдог.

АДБОУБ-н мэргэжлийн мэдэгдлийн форум (ММФ)

ММФ нь төрийн байгууллагын аудитын стандарт тогтоох асуудлыг шийдвэрлэх зорилгоор Удирдах зөвлөлөөс томилогдсон мэргэжлийн шинжээчдийн форум юм. МСХ, ЧБХ, МХМҮХ-той хамтран ажилладаг ММФ нь АДБОУБ-аас гаргасан мэргэжлийн мэдэгдлийн агуулга, чанарыг хариуцах ерөнхий үүргийг хүлээдэг. ММФ нь АДБОУБ-г олон улсын стандарт тогтоогч болгон бэхжүүлж, төрийн салбарын аудитын зохих стандартуудыг боловсруулахад хувь нэмэр оруулдаг.

Бүс нутгийн байгууллагууд



Тулгамдаж буй асуудлын хяналтын хороо

Тулгамдаж буй асуудлуудын хяналтын хороо (TAXX) нь АДБОУБ болон АДБ-уудад тулгараад байгаа чухал асуудлуудын талаар ИНТОСА-д тайлагнадаг бөгөөд болон байгууллагын эрсдэл зэрэг тулгамдсан асуудлаар мэдээлэл, зөвлөмжөөр хангадаг.

Бүс нутгийн байгууллагууд

АДБОУБ нь бүс нутгийн санаачилгаар дамжуулан гишүүдийнхээ хэрэгцээг хангах замаар АДБОУБ-г сурталчлах бүс нутгийн долоон байгууллагатай нягт хамтран ажилладаг. Эдгээр бүс нутгийн байгууллагууд нь бие даасан боловч өөрсдийн туршлага, мэдээллээ хуваалцдаг АДБОУБ-н чухал түншүүд юм. Эдгээр байгууллагад AFROSAI - Аудитын дээд байгууллагуудын Африкийн байгууллага; ARABOSAI - Аудитын дээд байгууллагуудын Арабын байгууллага; ASOSAI - Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага;

CAROSAI - Аудитын дээд байгууллагуудын Карибын байгууллага; EUROSAI - Аудитын дээд байгууллагуудын Европын байгууллага; OLACEFS - Аудитын дээд байгууллагуудын Латин Америк, Карибын байгууллага; PASAI - Аудитын дээд байгууллагуудын Номхон далайн холбоо багтдаг.

АДБОУБ-н Хөгжлийн санаачилга (Аи Ди Аи)

Аи Ди Аи голчлон хөгжиж буй орнуудын АДБ-ын үйл ажиллагаа, чадавхыг тогтвортой нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг АДБОУБ-н байгууллага юм. Энэ нь бүгдэд үнэ цэнэ, ашиг тусыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг үр өгөөжтэй, хариуцлагатай, хүртээмжтэй АДБ-ыг хөгжүүлэхийг эрмэлздэг.

Аи Ди Аи нь чадавхыг хөгжүүлэх одоо байгаа болон шинээр гарч ирж буй хэрэгцээ шаардлагыг хангахын тулд АДБОУБ-н бүс нутгийн байгууллагууд, АДБОУБ-н хороод,

Ажлын хэсгүүд, АДБОУБ-н бусад удирдагчид, АДБ-ууд, хөгжлийн түншүүд болон бусад харилцагч талуудтай хамтран ажилладаг. Мөн Аи Ди Аи АДБОУБ-Хандивлагч нарын хамтын ажиллагааг Глобал сангийн нэгжээрээ дамжуулан дэмжиж, АДБ-ын Гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалыг дэмжих чиг үүрэгтэй. Аи Ди Аи нь Норвеги улсад тусдаа хуулийн этгээд хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд Норвегийн Ерөнхий Аудиторын газар хариуцан үйл ажиллагааг нь явуулдаг.


АДБОУБ-Хандивлагч нарын хамтын ажиллагаа

АДБОУБ-Хандивлагч нарын хамтын ажиллагаа нь 2009 онд АДБОУБ болон хандивлагч нийгэмлэгүүд түнш орнуудад хариуцлагатай

байдал, ил тод байдал, сайн засаглал, төсвийн хөрөнгийн зохистой ашиглалтын сайжруулах хамтын зорилгыг хүлээн зөвшөөрөн 2009 онд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурснаар байгуулагдсан. АДБОУБ-Хандивлагч нарын ажиллагаа нь АДБОУБ болон хөгжлийн 23 түншийн хооронд байгуулсан дэлхийн стратегийн түншлэл юм.

Төрийн аудитын олон улсын сэтгүүл

Төрийн аудитын олон улсын сэтгүүл нь төрийн аудитын журам, арга техникийг сайжруулахад зориулагдсан АДБОУБ-н харилцаа холбооны үндсэн хэрэгсэл юм. Энэхүү сэтгүүлийг АНУ-ын АДБ, Төрийн хариуцлагын газар хариуцаж ажилладаг.





XXIX ИНКОСАИ
БРАЗИЛ
2022

Холбооны Бүгд Найрамдах Бразил улсын Рио-де-Жанейро хотноо 2022 оны 11 дүгээр сарын 7-ноос 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан АДБОУБ-ын XXIV Их хурал (ИНКОСАИ)-ын нээлтийн арга хэмжээ буюу 1 дүгээр хуралдаанаар тус байгууллагын 2023-2028 оны стратеги төлөвлөгөөг баталсан болно.

<https://incosai2022.rio.br/> ____



Англи хэл дээрх
Стратеги төлөвлөгөөтэй
энэ QR кодыг уншуулан
танилцана уу.

Please scan this QR
code for reading the
original English version.



СУРГАЛТ-2023

The image shows a background scene of a modern architectural complex. In the foreground, there's a large, ornate, golden-brown structure that looks like a monumental entrance or a part of a museum. It has a complex, multi-tiered design with many rectangular and triangular sections. To the left, a statue of a person riding a horse is visible. In the background, several tall, modern buildings with glass facades are visible under a clear sky. The entire image is overlaid with a grid of horizontal blue lines, which are evenly spaced and run across the width of the image. This grid is likely intended to serve as a template for a document or a presentation, where the lines can be used to guide the placement of text or other graphical elements.

Тэмдэглэл _____





Аудитын Дээд Байгууллагуудын Олон
Улсын Байгууллага